

Ж.ЦЭВЭЭНИЙ ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТУХАЙД

С.Түвшин

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Түүхийн тэнхим.

Өгүүлэлийн тоөч утга: Эл өгүүлэлд Монголын төр, нийгмийн зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, эрдэмтэн Ж.Цэвээний МАХН, ардын төрийн гадаад бодлогыг боловсруулахад хэрхэн оролцож явсан байдал, гадаад бодлогын үзэл баримтлалын гол чиглэлийг судлан өгүүлсэн болой.

Түлхүүр үгс: Гадаад бодлого, олон улсын харилцаа, хэлэлцээр, тусгаар тогтнол, хамтын ажиллагаа, өөртөө засан тогтнох эрх, тоөийг сахих, холбооны улс

Ж.Цэвээн Монголын тухайн үеийн удирдагч дотроос юм үзэж нүд тайлсан, эрдэмд боловсорсон нэгэн байсан тул шинэ тулгар улсын гадаад бодлогыг боловсруулах хэрэгт онцгой анхаарал тавьж байсан юм. Тэрбээр бүр Олноо өргөгдсөн Монгол улсын үед ёрөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэнгийн даалгавараар боловсруулсан "Улсын эрх" хэмээх үндсэн хуулийн шинжтэй баримт бичигт шинэ тулгар улсын гадаад бодлого, олон улсын харилцааны тухай хөндөн гадаад улстай гэрээ байгуулах, иргэд харилцан нэвтрэлцэх эрх зүйн үндсийг тодорхойлж байжээ. Энэ баримт бичигт: "Гадаад улс лугаа улсын ашигт холбогдолтой гэрээ байгуулсан ба байгуулах нь буй аваас мөн хурал дээр дотор тустай, тусгуй явдлыг шүүмжилж хэлэлцэнэ" 'хэмээгээд "хүн бүрт өөрийнхөө хэргээр аль тодорхой газар нэвтрэн явах эрх бий. Энэхүү нэвтрэн явалцах эрхийг харьяат улсын дотор ба гадаад улсад ч нэгэн адил хэрэглэнэ. Гагцхүү албаны хүн нар ноогдсон албаас зайлсхийх саналаар гадагш одвоос болохгүй" хэмээжээ. Мөн аливаа нэг улсын газар нутагт харийн хүн зорчих явдлыг олон улсад батлан тогтоосон хууль дүрмийн дагуу хийдэг болохыг "бас гадаад олон улсын дүрэмд үзвээс гаднаас ирсэн хүний суух явах эрхийг олон зүйлээр хэмжээлсэн байна. Үүний дотор болбоос гадаадын хүн нар олноор орж ирэн, газар орныг эзэрхэн элдэв явдал өдүүлбээс улс төрд будлиан гарах нь болзошгүй тул ийнхүү хэмжээлэн сэргийлэх нь болой"² гэжээ.

Ж.Цэвээн Олноо өргөгдсөн Монгол улсыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх асуудлаар Сайн ноён хан Намнансүрэн, чин ван Ханддорж наарт зөвлөж санал бодлоо илэрхийлж байсан билээ. Жишээ нь: Тэрээр Монгол улсын Ерөнхий сайд, гадаад явдлын яамны сайдын нэрийн өмнөөс Хаант Оросын сайд нарын Зөвлөлийн дарга Столыпин, Гадаад яамны сайд Сазонов нарын нэр дээр явуулах илгэлт бичгийн сэдвийг орос хэлээр бэлтгэж, бас Богд гэгээн Жавзандамба хутагтаас Оросын эзэн хаан II Николайд явуулах илгээлтийг бэлтгэж өгч байв. Дараагаар нь 1913 оны I сар; XI сарл Гадаад Монголын Ерөнхий сайд, Сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчлийд Пётрбургт айлчлахад тус төлөөлөгчдийг II Николай хаан Ливадид хүлээн авахад нь орчуулагчаар дагалдан явж байлаа.³

1914 онд Ж.Цэвээн Амоснавчиг хэмээх нууц нэр хэрэглэн, Монгол, Орос Хятад турван улсын хэлэлзээрт оролцож байлаа. Ж.Цэвээн хэлэлцээрийн 13 зүйлийн олонхийг бэлтгэсний дотор "Хаант Монгол улс нь Халх 4 аймагт, 150 хошуу, Өвөрлөгчийн 6 чуулган, 49 хошуу, Солон, Хөлөнбуйрын барга, элээт, орчин, хасаг, урианхай, дариганга нарыг багтаана" гэсэн зүйлүүдийг тусгаарлж байв. Ж.Цэвээн Монголын гадаад бодлогод их нөлөөтэй байсан нь В.Котвичтай

¹ Ж.Цэвээн. Түүвэр зохиолууд. I боть УБ., 1997 23 тал.

² Мөн тэнд 30 дахь тал.

³ Т.Кацухико. Талын хувьсгал. Тусгаар тогтнол сонин. УБ. 1991 он

харилцаж байсан захидалтуудад ч тодорхой хөндөгдсөн буй. Ийнхүү Ж.Цэвээн шинэ тогтсон Монгол улсын гадаад бодлого үйл ажиллагаанд жирийн нэг орчуулагч төдий бус бодлого боловсруулах зиндаанд оролцож байсан гэж үзэж болохоор байна.

Ж.Цэвээн 1917 онд Орос дахь хувьсгалт эргэлтийн дараа Буриад нутагтаа нийгмийн өөрчлөн байгуулалтанд идэвхитэй оролцох болжээ. Тэрбээр 1917 оны XII сард хуралдсан бүх буриадын IV хурлаас Буриадын үндэсний төв хорооны даргаар сонгогдож, улмаар чин зүтгэл гарган ажилласаны үрээр 1918 оны III-IV сард Чита хотноо чуулсан Өвөр Байгал мужийн ажилчид, тариачид, казак, буриадын төлөөлөгчдийн III хурлаар буриадын ард түмний тусгаар тогтох эрхтэй хэмээн анх удаа хүлээн зөвшөөрсөн тунхаг гаргуулжээ. Тэрбээр пан монголизмын үзэлтэн байсан боловч, атаман Сөмёновын нөлөөн дор байгуулсан Нармай Монгол улсын Гадаад явдлын яамны сайдаар ажиллуулах саналыг хүлээж аваагүй юм.

Ж.Цэвээн 1920 оноос Монголд өрнөсөн хувьсгалт хөдөлгөөнийг талархан дэмжиж, Эрхүү дэх Коминтерний Алс дорнодын нарийн бичгийн дарга нарын газар ажиллах болжээ. 1920 оны XI сарын 10-нд анх нийтлэгдсэн "Монгол үнэн" сонин Ж.Цэвээний шууд оролцоотойгоор гарч байсан юм. Тус сонины олон өгүүлэлүүдэд шинэ тогтох төрийн гадаад бодлоготой холбоотой асуудлыг хөнджээ. "Монгол улсын боловсрон мандах явдалын тус" хэмээх өгүүлэлд: "... Монгол язгуурын олон ард нь дэлхий дахины их улс нарын дарлагдсан ард түмэн ба олон язгуурын бага улсууд лугаа санал хүчээ хамтруулан хөдлөлцөж, эрх мэдлээ өөрсдийн гарт авч язгуур үндсээ бадруулан гадаад лугаа адил эрдэм соёлыг дэгжүүлэн боловсрохын тул нэгэн санаа нийтийн хүчээр идэвхитэй зүтгэмжлэн оролцох цаг болов"⁴ хэмээн бичсэн байна. Бусад олон өгүүлэлд өмнөд, хойт их хөрштэйгээ найрсаг харилцаатай байж, хамтран ажиллахыг ухуулан уриалжээ.

Ж.Цэвээн Монгол Ардын Намын I их хуралд бэлтгэх, намын мөрийн хөтөлбөр боловсруулах явцдаа монголчууд тусгаар тогтнолоо олж авсны дараа гадаад бодлоготоо ямар зарчим баримтлах, монгол туурагтныг нэгэн дээвэр дор нэгтгэх асуудалд багагүй анхаарал тавьжээ. "Монгол ардын намаас Гадаад Монголын түмэнд тунхаглан зарлах бичиг"-ийн гуравдугаар зүйлд: "... хараахан дундат иргэн улсын хүний тоо маш олон, муж хязгаар, үндэс суртал хэд хэд буй учраас зүй нь мөн хэд хэдэн анги өөрөө зээрхэн засах улс байгуулан, өөр хоорондоо гэрээ дүрэм тогтоож, тангарагийн холбоот дундуудаа улс болбаас зохих тул манай монгол үндэстэн мөн энэ холбоонд багтан оролцооос татгалзах явдалгүй харин ч Өмнөд Хятад, Умард Хятад, Сычуань хязгаар, Төвд, хотон, манж монгол зэргээр дор дороо өөрөө зээрхэн шударга засаг байгуулж, тусгаар тогтоод, бүгд хоорондоо нэгэн хэлхээ баталж, холбоот улс байгуулбал сая харилцан бие биеэ дарлалцахгүй болоод гадаад зээрхэг түрэмгий аюулаас хамгаалахад сайн⁵ гэжээ. Энд юуны өмнө монголчууд өөртөө засан тогтох эрх олж авах, улмаар холбоонд нэгтгэх санаа дэвшиүүлсэн нь Монгол үндэстнийг нэгэн дээвэр дор нэгтгэх, улмаар ойр зэргэлдээ орнуудтай сайн хөршийн харилцаатай байх үзэл санааг илэрхийлжээ. "Холбооны улс" байгуулах үзэл санаа нь тактикийн шинжтэй илэрхийлэл байсан болов уу. Ж.Цэвээн шинэ тутам байгуулагдсан МАН-ын гадаад харилцааг өргөтгөх ажилд бүр эхнээс нь оролцож байв.

1921 оны V сарын 7-нд Коминтерны Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүн Б.З.Шумяцкий "удахгүй Москва хотноо нээгдэх Коммунист Интернационалын III их хуралд Монгол Ардын засгийн хэргийг бүгд захиран

⁴ МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд.(1920-1940 он) I дэвтэр, УБ., 1966 т.16.

⁵ МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд.(1920-1940 он) I дэвтэр, УБ., 1966 т. 34-35

шийтгэх газрын ерөнхий дарга Д.Бодоо, түшмэл Ж.Цэвээн нарыг төлөөлөгчөөр томилон оролцуулна уу" хэмээн нэр заан урьж, Монгол Ардын намын Төв хороонд цахилгаан утас ирүүлж байжээ.

Мөн сарын 8-нд Засгийн хэргийг бүгд захиран шийтгэх газрын тэргүүлэгчдийн хурлаар уг асуудлыг хэлэлцэхэд: "Сдоо цаг чухал бөгөөд улсын албан хэрэг үлэмжхэн тул Ерөнхий дарга Бодоогийн оронд" Эрдэнэ вангийн хошууны хүнд Хоролыг (Хорлоог) Бегзееев хэмээх Ж.Цэвээний хамт томилон явуулахаар шийдвэрлэж, тэдэнд "Монгол Улс ба Зөвлөлт засагт Их Орос улсын олон яамны эрх баригчид лугаа зевлөн хэлэлцэх" бүрэн эрх олгожээ. Иймд тэд зөвхөн Коминтерний их хуралд оролцох Монгол Ардын намын төлөөлөгч төдийгүй, Монгол Ардын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн үүргийг давхар гүйцэтгэхээр болсон байна.

Ерөнхий дарга Бодоогоос хүнд Хорлоод шийтгэн олгосон үнэмлэх бичгийг 1921 оны V сарын 11-нээр өндөрлөснөөс үзэхэд төлөөлөгчид, мөн сарын дундуур Хиагтаас гарсан бололтой.

Цагаантны гол хүчин бут цохигдоод, Ардын журамт цэрэг Нийслэл Хүрээний зүг хөдлөхөөр бэлтгэж байсан үед Монгол Ардын түр засгийн газар, Монгол Ардын Намын Төв Хороо гэсэн нэртэй цахилгаан утас Ж.Цэвээн, хүнд Хорол нарт явуулжээ. Энэхүү цахилгааныг Москвад хүлээн авах үед Ж.Цэвээн, хүнд Хорлоо нар Коминтерны III их хуралд сууж МАН-аас тус хуралд өргөн барьсан баярын бичгийг VI сарын 22-нд үншиж гардуулад, Петроград хот руу явсан байна.

Энэ хооронд Монгол орны цэрэг улс төрийн байдалд үндсэн эргэлт гарч, Ардын журамт цэрэг Нийслэл Хүрээг чөлөөлөөд, Ардын түр Засгийн газар, Ардын Намын Төв Хороо тэнд шилжин ирсэн байв. Коминтерны бүрэн эрхт төлөөлөгч Б.З. Шумяцкий эл байдлыг тусган цахилгаан утсыг VII сарын 8-нд Ж.Цэвээнд явуулжээ. Тэр цахилгаанд хэлэхдээ: "Танай Засгийн газраас Таны нэр дээр үүний өмнө ирүүлсэн цахилгаан утсанд Зөвлөлт Оросын цэргийн ангийг Нийслэл хүрээнд үлдээх талаар ирүүлсэн саналыг би Г.Чичерин, Л.Карахран нартай ярилцав... Та өөрийн бүрэн эрхийн дагуу Монгол Ардын түр Засгийн газрын нэрийн өмнөөс Зөвлөлт Орос Улсын Гадаад хэргийн Ардын Комиссариатад дээрхи хүсэлтийг цахилгаанаар мэдэгдэнэ уу" гэжээ. Сайхь цахилгааныг хүлээн аваад Монголын төлөөлөгчдийн дарга Ж.Цэвээн гишүүн Хорол, нарийн бичгийн дарга Ванчиков (Баламсу) нарын гарын үсэгтэй цахилгаан утсыг Петроградаас Г.Чичеринд илгээжээ.

Монгол Ардын Хувьсгалт Засгийн Бегзееев (Ж.Цэвээний нууц нэр) тэргүүтэй төлөөлөгчдийг Зөвлөлт Орос Улсын Гадаад хэргийн Ардын комиссар Г.Б. Чичерин хүлээн авч уулзажээ. Энэ уулзалтын үеэр Зөвлөлт Орос улс, Монгол Улс хоорондын асуудал, мөн бусад асуудлыг хэлэлцсэн билээ.

Ж.Цэвээн нар Петроградаас Москвад буцаж ирээд VII сарын 12-нд Гадаад хэргийн Ардын комиссариатын орлогч Л.Карахантай, мөн сарын 18-нд Зөвлөлт Орос Улсын санхүүгийн хэрэг эрхлэх комиссар Альский тус тус уулзаж, хэлэлцээ хийсний дунд олон арван асуудлаар харилцан тохиролцжээ. Ийнхүү Ж.Цэвээн хувьсгалын анхны өдрүүдэс Ардын Засгийн гадаад бодлого үйл ажиллаганд ажил хэрэгчээр оролцож байв.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараа Ж.Цэвээн улс орны хэтийн төлөвийн асуудалд ихээхэн санаа зовьниж, олон чухал асуудлыг боловсруулсны нэг нь шинэ тулгар Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал боловсруулах зиндаад нэгэнт хүрсэн улс төрийн томоохон зүтгэлтэн, нэрт эрдэмтэн хүн байв.

Ж.Цэвээн шинэ тутам Монгол улс бол ЗХУ, Дундат иргэн улсаар хүлээн зөвшөөрөгдсөн, дэлхий олон улс тугаа барилдлага, хэлхээ тогтоосон бие даасан улс байх ёстой гэж үзэж байв. 1923 онд МАН-ын II хурлаар батлагдсан "Эдийн

засгийн үндсэн бодлого" хэмээх баримт бичигт тус улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийг "...харилцан худалдаа ашиг, эрдэм соёлын тухай гэрээ болзоо тогтоон нэвтрэлцэхэд хүрвэл эрхбиш хэдэн давхар эрэгцүүлэн хянаж тогтоовол зохино. Герман, Англи, Орос, Америк, Хятад, Рибин (Япон) хэмээн шилэн сонгоход хүрвэл аль талаар Герман, Орос, Америк хэмээх мэтээр дэс дараалан орноо заа"⁶ гэсэн нь Ж.Цэвээн нарын үндэсний ардчилсан үзэлтнүүдийн гадаад бодлогын чиг шугам байв. Тэдний бодлого Герман улстай худалдаа, соёлын харилцаа өргөжүүлэх, оюутан, сурагчид суралцуулах, нам, эдийн засгийн удирдагчид өрнө, дорны орнуудаар явж юм үзэж нүзد тайлах, тандах зэргээр илэрч байлаа.

Ж.Цэвээн Монгол улсын гадаад бодлогын талаарх бодол санаа үзэл баримтлалын шинжтэй боловсрогдож байсныг 1931 оны VIII сарын 15-наар огноолсон "Ард Жамсраны Цэвээнээс Ардын Хувьсгалт Намын Төв Хороонд" гэсэн өргөдлөөс харж болно. Эл өргөдөлд: Улс төрийн талаар бол тусгаар, биеэ даааж засаад, үнэхээр бусдад үл захирагдан, дан ганц СССР-ээс зөвшөөрөн хүлээсэн төдийгээр зогсохгүй бас Хятад ба бусад олон улсаар зөвшөөрөн хүлээгдсэн бүрэн эрхт улс болох хэрэгтэй. Хятадын хэмжээтэй эзэрхийлэл ч хэрэггүй, СССР-ийн дангаар эзэмшин хамгаалах эрхийн дор орох хэрэггүй"⁷ гээд "... СССР, Хятад хоёроос баталсан бөгөөд бусад олон улсаас зөвшөөрөн хүлээсэн төвийг сахих улс болох хэрэгтэй. Энэ нь үлгэр(лэвээс) Швейцари улс лугаа адил буй" хэмээжээ. Эндээс МАН-ын анхны мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн "Холбооны улс"-ын тухай үзэл санаа нь тактикийн шинжтэй илэрхийлэл байсныг бүрнээ харж болох бөгөөд нэг улс руу хэт хэвийсэн өрөөсгөл бодлого явуулахаас татгалзаж, аль болохоор төвийг сахихыг хичээсэн гадаад бодлого явуулах санааг тод томруун дэвшүүлсэн байна.

Ж.Цэвээн тусгаар тогтолоо мандуулсан Монголоор төвлөрсөн эсгий туургатаны үндэстний нэгдсэн улс байгуулах үзэл санааг тов тодорхой тавьж байсан юм. Тэрбээр төвийг сахисан Монгол улс нь ЗХУ-ын тусламж, бусад орнуудтай холбоо тогтоосноор орчин тойрны Монголчууд бусад бага буурай үндэстнүүдэд үлгэр дуурайлал болохуйцаар хөгжиж дэвшихийг гол болгох чухал гэж тэмдэглээд: "Монгол ард улсыг тойрон, Монгол овогтны нэг холбоо байгуулж болно. Хэмээх бөгөөд үүнд хятадын нүүдлийн иргэний далайд живж бүхий Жирэм, Ёст, Зүү- үд энэ турван зуун чуулганы монголчууд нь өөрсдийн сайн дураар Монгол улсын газарт нүүдлэн ирцгээж болох... Үүнээс цааш явбаас Хөх нуур, Төвд, Хятадын Туркестан эдгээр нь Монгол Ард улсыг тойрон ирээдүйд тусгаар тогтоо Төв Азийн Холбоот Улсын гишүүн мөн бөгөөд СССР улсаар түшиг хийж, СССР улс лугаа тангарагийн гэрээ бүхий СССР-ийн Холбоонд орохгүй, СССР-т захирагдахгүй тийм нэгэн Төвийн Азийн Холбоот Улс болохыг хүсэх ажгуу. Эдгэрхүү газар оронд оршин суух монгол овогтон нь манай Монгол ба Улаанбаатар лугаа эрдэм соёлын холбоотой байх хэрэгтэй бөгөөд Дотоод Монгол, Хөх нуур зэрэг газрын үзүүрт Улаанбаатар нь Москва адил болох хэрэгтэй"⁸ гэжээ.

Чингэхлээр Ж.Цэвээний гадаад бодлогын үзэл баримтлалын гол агуулга нь:

- Монгол улс бол түүхийн тодорхой он цагийн хэрчимд төвийг сахисан улс байх;
- Монгол улс Монгол туургатан бусад бага буурай улсуудтай нягт хэлхээ холбоо тоггосж, тэдэнд үлгэр дуурайлал болохуйцаар хөгжих;
- ЗХУ-ын тусламжинд түшиглэх боловч, ашигтай бол ямар ч улс түрэнтэй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх;

⁶ МАН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд.(1920-1940 он) I дэвтэр, УБ., 1966 т. 100

⁷ МАН-ын Төв архив. Ф-4, д-4 хн-36

⁸ МАН-ын Төв архив. Ф-4, д-4 хн-36

- Яваандаа Монгол туургатны нэгдсэн улс байгуулахыг эрмэлзэх явдалд оршино.

Abstract:

This article about the doctrine and concepts of development of Jamsrano Tseveen the eminent Mongolian scholar, famous statesman, about his role in elaboration of main concepts of foreign policy.

Ном зүй

1. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичигүүд.(1920-1940 он) I дэвтэр,
Улаанбаатар., 1966.
2. МАХН-ын Төв архив. Ф-4., д-4 хн-36
3. Т.Кацухико. Талын хувьсгал. Тусгаар тогтиол сонин. УБ. 1991 он
4. Ж.Цэвээн. Түүвэр зохиолууд. I боть УБ., 1997 он